

Энэхүү хичээлийн арга зүйн санаа нь ээлжит хичээлийг төлөвлөх, заах багшийн арга зүйг сайжруулах, сурагчдын сурлагын амжилтыг ахиулах, сургууль, багш нар сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

### Үнэлгээний даалгавар, сурагчдын гүйцэтгэл


Даалгаврын зорилго: Нийгмийн ухааны шинжлэн судлах арга барилын эхний алхам болох таамаглал дэвшүүлэх алхмыг ялгах

Хүснэгт 4. Сурагчдын гүйцэтгэл

Хариултын дугаар	Хариулт	Гүйцэтгэл %	Зөв хариулт
1	А	32.2	
2	Б	23.6	
3	В	10.4	+
4	Г	29.2	
5	Огт хариулаагүй	2.6	
6	Хүчингүй хариулт	1.9	

Шинжилгээний үр дүн, асуудал: Сорилд оролцсон сурагчдын 10.4 хувь нь нийгмийн ухааны хичээлд шинжлэн судлах арга барилын эхний алхам болох таамаглалыг зөв нэрлэсэн. Таамаглал ба мэдээллийн ялгааг таних чадвар сул байна. Жишээ нь, хүн амын тооллогын дүнгээр Монгол улсад хүний дундаж наслалт 67 байна гэсэн хувилбарыг сурагчдын 32.2 хувь нь сонгосон байна. Цөөнгүй сурагч таамаглал гэж хичээл дээр судлаагүй гэж бичсэн байна. Уг арга барилыг нийгмийн ухааны хичээлд төдийлэн хэрэглэхгүй байгаа нь ажиглагдаж байна.

### ХИЧЭЭЛИЙН АРГА ЗҮЙН САНААНЫ ЖИШЭЭ

Нийгмийг шинжлэн судлах (НШС) арга барилын алхмууд (үе шат)	Арга зүйн санаа
А. Асуудал, таамаглал дэвшүүлэх	<p>А. I хувилбар: - Сурагчид дараах зургийг ажиглаж, НШС арга барилын эхний алхам аль нь болохыг олж, үндэслэлээ тайлбарлана.</p>  <p>II хувилбар: Дараах тохиолдолд сурагчид багаар ажиллаж, шинжлэн судлах асуудал (таамаглал)-ыг дэвшүүлнэ.</p>

**Тохиолдол**

Найрамдал паркийн орчимд гуравхан сарын өмнө босгосон нутгийн зураачийн хөшөөний гарыг хэн нэг нь хугалжээ. Ганц хөшөө гэлтгүй нийтийн эзэмшлийн эд зүйлсийг эвдлэн сүйтгэх явдал гарсаар байна. Хэдэн жилийн өмнө хойд замын гэрэлтүүлгийн бүрхүүлийг хаг цохьсон бол өнгөрсөн жил шинээр хийсэн автобусны зогсоолыг эвдсэн тохиолдол мөн гарчээ.

*Эх сурвалж: “Дорнодын мэдээ” сонин Нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг сүйтгэхээ болих хэрэгтэй. 2014 оны 12-р сар.*

Асуулт: Тохиолдолд тулгуурлан, шинжлэн судлах ямар асуудал (таамаглал)-ыг дэвшүүлж болох вэ?

Сурагчийн дэвшүүлж болох асуудал(таамаглал) 1.

Нутгийн хүүхэд, залуус, иргэн бүрийн боловсрол, хүмүүжлийг дээшлүүлбэл нийтийн эзэмшлийн эд зүйлсийг эвдлэн сүйтгэх явдал эрс багасна.

Сурагчийн дэвшүүлж болох асуудал(таамаглал) 2.

Нутгийн хүмүүсийн хандлагыг эерэгээр өөрчлөх ажил зохион байгуулбал тэд нийтийн эзэмшилтэй хайр гамтай харилцана.

Б. Шинжлэх үйлийн төлөвлөгөө гаргах

Б. Шийдэх асуудал (таамаглал)-ын хүрээнд судлах, мэдээлэл цуглуулах юмс, үзэгдлийг багаар, оюуны довтолгооны аргаар ярилцан дараах байдлаар гаргаж болно. Үүнд:

- |   |                           |
|---|---------------------------|
| - Траншей                                 | - Нийтийн бие засах газар |
| - Нийтийн талбай                          | - Ундны усны худаг        |
| - Орон сууц                               | - Цэцэрлэгт хүрээлэн      |
| - Барилга, байшин                         | - Тоглоомын газар         |
| - Нус цэрээ гадаа, машиныхаа цонхоор хаях | - Бэлчээр, хадлан         |
| - Нийт хөлхсөн гудамжинд тамхи татах г.м. |                           |

В. Төлөвлөгөөний хүрээнд мэдээлэл цуглуулах

В. Дэвшүүлсэн асуудал (таамаглал)-ыг шийдэх эрэл хайгуул хийх, мэдээлэл цуглуулах үйлийн төлөвлөгөө (загвар):

№	Судлах үзэгдэл, юмс	Мэдээлэл цуглуулах арга	Мэдээлэл боловсруулалт, нотолгоо	Танилцуулах хэлбэр
1	Нийтийн орон сууц, траншейтай харилцах	Ажиглалт Тохиолдол шинжлэх		
2	Тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэнтэй харилцах	Ажиглалт Сурвалжлага хийх		
3	Нийтийн эзэмшил газар, бие засах байртай харилцах	Холбогдох судалгаа, мэдээллийг шинжлэх		
4	Нийт хөлхсөн гудамжинд нус цэрээ хаях, тамхи татах үйлдэл	Телевизийн мэдээ, дүрс бичлэгт анализ хийх		
5	Нийтийн ундны усны худаг, нутаг бэлчээртэй харилцах г.м.	Холбогдох мэдээлэл, тохиолдол шинжлэх Ярилцлага, сурвалжлага хийх г.м.		

	<p>5 багаар ажиллаж, дээрх юмс, үзэгдлийг сурагчид өөрсдийн ажиглалт, төсөөлөл болон холбогдох эх сурвалжид тулгуурлан судалж, цуглуулсан мэдээллээ нэгтгэн боловсруулна.</p> <p>Жишээ нь, Тухайн нэг баг дээрх юмс, үзэгдлээс нийтийн орон сууц, траншейтэй харилцах асуудлыг шинжлэн судална.</p> <p>В. Судалгааны мэдээллийг цуглуулах төрөл нь: Сургуулийнхаа ойр орчмын нийтийн эзэмшлийн орон сууцны дараах зүйлсийг судалж, мэдээлэл цуглуулах</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Сургуулийн ойр орчмын орон сууц болон траншейны нийт тоог гаргах</li> <li>2. Траншейг ажиглахдаа: <ul style="list-style-type: none"> <li>• Траншейнд хогоо хаясан эсэх ?</li> <li>• Таг онгойсон хэд?</li> <li>• Тагийг авч хаясан хэд?</li> <li>• Тагийг хагалсан хэд?</li> </ul> </li> <li>3. Орон сууцыг ажиглахдаа: <ul style="list-style-type: none"> <li>• Орцны байдал</li> <li>• Хана, хаалган дээр элдэв зүйл бичсэн, зурсан эсэх</li> <li>• Цахилгаан шатны гэрэл, камерийн байдал</li> <li>• Сууцны эргэн тойрон хог байгаа эсэх (цонхоор хогоо хаядаг эсэх)</li> </ul> </li> </ol> <p>Эдгээрийн талаарх мэдээллийг ажиглалтын тэмдэглэл, зураг, дүрс бичлэг хийх зэрэг аргаар баталгаажуулна.</p>
<p>Г. Мэдээлэл боловсруулах</p>	<p>Г. Мэдээллийг боловсруулах явц, үр дүн:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Дээрх мэдээллийн төрөл, тоо, чанарын үр дүнг орон сууц тус бүрээр графикаар дүрсэлж харьцуулах.</li> </ul>
<p>Д. Мэдээллийг нягтлан нотлох</p>	<p>Д. - Дээрх юмс, үзэгдлээр гаргасан мэдээллийн төрлүүдийн үнэн, бодитойг хянан нягтална. Ажиглалтын тэмдэглэл, зураг, дүрс бичлэгээ хавсаргана.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Мэдээллийн төрөл бүрийн нөхцөл, шалтгаан, үр дагаврыг тодруулж, нотлоно. Тухайлбал, орон сууцны дотор, гадна ханан дээр элдэв зүйл бичих, зурах, траншейны тагийг онгойлгох зэрэг нь хүмүүсийн нийтийн эзэмшлийн эд зүйлстэй харилцах ёс суртахуун, хүмүүжил, зан үйлийн доголдолтой холбоотойг тодруулж, хэрхэн засах, сайжруулах арга замыг багаар хэлэлцэж, нотолж, батална.</li> <li>• Нийтийн орон сууц, траншейтай зүй бус харилцах нөхцөл, шалтгаан, үр дагавар, эдгээртэй хэрхэн зөв харилцах соёл, арга замын талаар зөвлөмж боловсруулна. Зөвлөмжид нийтийн орон сууц, траншейтэй зүй бус харилцах нь хүмүүсийн боловсрол, хүмүүжил, нийтийн дунд биеэ авч явах зан үйлтэй холбоотой болон түүнийг засах, сайжруулах арга замын талаар тусгана.</li> <li>• Зөвлөмжөө сургуулийн удирдлага, олон нийт, харьяа хороо, дүүрэгтээ танилцуулж, иргэдэд сурталчилах.</li> </ul>
<p>Е. Танилцуулах</p>	<p>Е. Баг бүр судалгааны үр дүнг танилцуулах хэлбэрээ сонгоно. Цахимаар, цаасан хэлбэрээр, аман илтгэлээр танилцуулах боломжтой.</p>

#### Багшид нэмэлт зөвлөмж

- НШС арга барилын асуудал (таамаглал) дэвшүүлэх, шинжлэн судлах үйлээ төлөвлөх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, нягтлан нотлох, танилцуулах гэсэн цогц алхам буюу бүтцийг хичээлийн эхэнд, сурагчдад үйлийн баримжаа болгож, оновчтой аргаар, маш товч танилцуулж болно.
- Эсвэл, тухайн алхам бүрд сурагчдыг ажиллуулж, хичээлийн дүгнэлт хэсэгт сурагчдаар өөрсдөөр нь цогц алхмууд буюу бүтцийг гаргуулж болно.
- Тухайн шинжлэн судлах арга барилыг сурагч бүр эзэмшихэд цогц алхмуудыг нь нэгж хичээлээр тодорхой төлөвлөхөд анхаараарай.
- Шинжлэн судлах арга барилын асуудал (таамаглал), ялангуяа асуудал дэвшүүлэх алхмыг ээлжит хичээл бүрээр хэрэгжүүлэх бололцоотойг анхаарах хэрэгтэй.
- НШС арга барил эзэмших хичээлийг 80 минутаар төлөвлөн хэрэгжүүлж болохыг анхаарна уу.
- “Шинэ мэдлэг, санаа гарган авахад чиглэсэн, нийгмийн үзэгдэл, үйл явцын шалтгаан, шинж чанар, холбоо, харилцааны талаарх урьдчилсан төсөөллийг таамаглал” гэнэ. Таамаглал нь тухайн шинжлэн судлах арга барилын эхний алхам, бас хэрэгсэл гэдгийг сурагчдад цэгцлэн тодотгож өгөөрэй.

Эх сурвалж: БХ., (2019) ., “ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн нөхцөл байдлын судалгаа”, УБ.

Боловсруулсан: Проф.О.Пүрэв (БХ,БХСС)